

**АРД ДААТГАЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Хурлын огноо: 2025 оны 4 сарын 29-ний өдөр

Хурлын байршил: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Сентрал Тауэр, 17 давхар, Криптос хурлын танхим, Ард Апп
Хурал эхэлсэн цаг: 11 цаг 00 минут

Хурлын дарга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн Б.Болорчимэг

Хурлын ирц: Нийт саналын эрхтэй хувьцааны тоо 25,000,000 ширхэг, хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо 17,244,893 ширхэг буюу 69 хувь

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан танилцуулах;
2. 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт танилцуулах;
3. Ногдол ашгийн тайлан танилцуулах;
4. 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
5. 2025 оны ТУЗ-ийн төсөв танилцуулах;
6. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулж батлуулах тухай;
7. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;
8. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай;

Тэмдэглэл:

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл: Сайн байцгаана уу? Өнөөдөр буюу 2025 оны 4 сарын 29-ний 11:00 цагт Ард Даатгал ХК-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарласан байгаа. Та бүхэнд түрүүн хэлсэнчлэн 11:00-11:10 хүртэл ирцийн бүртгэлийг үүдний хэсэг болон Ард Апп-р бүртгэсэн. Өнөөдрийн хуралд Компанийн тухай хуулийн 67-р зүйлд заасанчлан Тооллогын Комиссын эрх үүргийг хэрэгжүүлэхээр тооллогын комиссын даргаар миний бие Ө. Бямбагэрэл, тооллогын комиссын гишүүдээр Ч.Даваацэрэн, А.Эрхбилгүүн нар тус тус ажиллаж байна. Өнөөдрийн хурлын дэгийн дагуу хурлын ирцийн баталгаажуулалтыг та бүхэнд танилцуулъя. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтын дагуу 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан Тооллогын комиссын тогтоолоор хурлын ирцийг баталгаажуулсан болно. Ард Даатгал ХК нь нийт 25 сая ширхэг энгийн хувьцаа гаргасан бөгөөд өнөөдрийн хуралд саналын эрх бүхий 17,244,893 ширхэг хувьцаа, өөрөөр хэлбэл 68.9 хувийн ирцтэйгээр хувьцаа эзэмшигчид оролцож байна. Иймд Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурал хүчин төгөлдөр болох нөхцөл хангагдсан болохыг албан ёсоор мэдэгдэж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

ХЭХ-н дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Болорчимэг: За сайн байцгаана уу? Та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Цаг заваа гарган өнөөдрийнхөө хувьцаа эзэмшигчдийнхээ хуралд хүрэлцэн ирсэн явдалд та бүхэндээ талархал илэрхийлье. Жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн маань хурал тогтсон дэг, хөтөлбөрийн дагуу явагддаг. Өнгөрсөн жилийнхээ ололт амжилт, онцлох үйл явдлуудыг хэлэлцэнэ. Өнөөдрийн хурлын онцлох явдал бол Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдээ шинээр сонгох байгаа. Иймд та бүхэн минь саналаа идэвхтэй өгөөрэй. Ингээд өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурал нээснийг мэдэгдье. Хурлын дэгийн дагуу эхний хэлэлцэх асуудал маань 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулахаар байгаа. Энэхүү хэсгийг танилцуулж өгнө үү хэмээн компанийн гүйцэтгэх захирал Н.Эрдэнэтулга таныг урьж байна.

Ард даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Эрдэнэтулга: За сайн байцгаана уу? Та бүхнийг хүрэлцэн ирсэнд баярлалаа. Өнгөрсөн жил миний бие томилогдсоноос хойш ТУЗ-н хурлаар компанийн бүтцээ дахин шинэчилсэн. Энэ хүрээнд нөхөн төлбөр болон эрсдэлийн удирдлагын газрыг шинээр бий болгосон. Өнгөрсөн жил даатгалын салбарын 90 жил, мөн манай компанийн 30 жилийн ой болсон. Энэ ойн баярын хүрээнд маш олон ажлуудыг зохион байгуулсан. Томоохон онцлох үйл явдлуудаас дурдвал 2023 оны тайланг Grant Thornton аудитаар баталгаажуулсан, мөн 750 сая төгрөгийн ногдол ашиг буюу нэгж хувьцаанд 30 төгрөгийг олгосон. Эрсдэлийн удирдлагатай холбоотойгоор Лондонд төвтэй Tyser хэмээх брокероос эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг хамтран зохион байгуулсан. Өнгөрсөн жил хийсэн 3 том ажлын нэг болох даатгагчийн баталгаатай холбоотой ажил байгаа. Энэ нь жижиг дунд аж ахуйн нэгжүүдийн бэлэн мөнгөний урсгалыг сайжруулах, тендерт оролцоход дэмжих зорилготой даатгалын салбараас хийгдсэн хамгийн чухал ажил болсон. Энэ хүрээнд Ард Даатгал ХК нь манлайлан ажиллаж нийтдээ 140 гаруй даатгагчийн баталгаа гаргаж 500 гаруй сая төгрөгийн орлогыг компанидаа төвлөрүүлсэн. Мөн Ард Санхүүгийн Нэгдлийн охин компанийн хувиар Crypto Week-д амжилттай оролцсон бөгөөд мөн хувьцаа эзэмшигчдийн хурлаа амжилттай зохион байгуулсан байгаа. Сүүлийн жилүүдэд бид нийгмийн хариуцлага гэж ярьдаг байсан бол одоо тогтвортой хөгжил гэх дараагийн түвшинд шилжсэн байгаа. Байгаль орчин, нийгэм засаглалд хандсан үйл ажиллагааг маш өргөн хүрээнд зохион байгуулсан. Тогтвортой хөгжлийн бид нар тогтвортой хөгжлийн тайлагналын олон улсын байгууллагын зарчмаар өндөр хөгжилтэй орны даатгалын компаниудын тэр гаргадаг жишгээр Ард Даатгал ХК нь салбартаа анх удаа тогтвортой хөгжлийн тайлангаа гаргасан. Тогтвортой хөгжлийн тайлан гэдэг нь хамгийн хямд зардлаар ирээдүйдээ баялгаа үлдээх зорилготой үйл ажиллагаа гэж товчхондоо хэлж болно. Энд бол зөвхөн байгаль орчинтой холбоотой үйл ажиллагаа биш жендер болон ажил эрхлэлт, эдийн засаг болон боловсролыг дэмжих нийтдээ 17 НҮБ-с гаргасан зорилтуудаас боловсрол, байгаль орчин, эдийн засгийн хөгжлийг дэмжих ийм 3 зорилтыг биелүүлсэн тухайгаа тусгасан. Манай вебсайт дээр байгаа. Та бүхэн бас танилцаарай. Дараагийн нэг асуудал бол жолоочийн даатгалын автомат сунгалт болон нөхөн төлбөр олголт иргэд рүү,

даатгуулагч руугаа чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулсан. 2023 онд бидний жолоочийн хариуцлагын даатгуулагчийн тоо 140 орчим мянга байсан бол 2024 онд 190 мянга гаруйд хүрч улсдаа жолоочийн хариуцлагын даатгалаар хамгийн том компани болсон. Тэгэхээр бид ийм олон хүмүүст хүрч ажиллахын тулд цахим систем, ERP систем нэвтрүүлэх зүй ёсны шаардлага урган гарч ирдэг. Мөн 90 жилийн ойн хүрээнд хавдар буюу эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн салбарт даатгалын компанийн оролцооны асуудлыг хөндөж хурал, форумыг зохион байгуулсан. Дараагаар бид боловсролыг дэмжсэн эрдэм шинжилгээний хурал, түгжрэл болон зам тээврийн ослыг бууруулах хууль эрх зүйн уулзалт болон тээврийн хэрэгслийн даатгалын аян эхлүүлсэн. Төрийн банктай холбоотойгоор хувьцаа эзэмшигч нартаа сонирхуулахад Төрийн банкин дээр ногоон зээлтэй холбоотой даатгалын үйлчилгээг бид нар санаачлаад хэрэгжүүлэхэд бэлэн болсон, санхүүжилт шийдэгдвэл ойрын хугацаанд хэрэгжүүлнэ. Энэ бол эрчим хүчний хэмнэлттэй орон сууц буюу дулаан алдалтыг 20 хувь бууруулсан ийм амины орон сууцанд даатгагчийн баталгаа гаргаж санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Үндэсний давхар даатгалын ганцхан компани байдаг. Энэ компанитай хамтраад Эрсдэлд тэсвэртэй Монгол улс гээд зөвхөн даатгалын салбартай холбоотой асуудлууд, ган, зуд, үер ус, газар хөдлөлт, гамшгийн асуудалтай холбоотой даатгалын асуудлуудыг маш өргөн хүрээнд ярьсан. Зөвхөн өнгөрсөн жилд даатгалын салбарт МИД-р 16 орчим тэрбум төгрөгийг зудад төлснөөс Ард Даатгал компани 700 орчим сая төгрөгийг зөвхөн малчдадаа олгосон. За одоо компанийнхаа гол үзүүлэлтүүдийг танилцуулъя. 2024 онд манай нийт 51 тэрбум төгрөгт хүрж, хураамжийн орлого 45 тэрбум төгрөгт хүрээд байна. Энэ үзүүлэлтүүдээрээ бид даатгалын салбарт эхний 3-т, зах зээлдээ 10 хувийг эзлээд байна. Олгосон нөхөн төлбөрийн хувьд 19.5 тэрбум, цэвэр ашгийн хувьд 2.4 тэрбум төгрөг харин нөөц сангийн хувьд 26.9 тэрбумд хүрээд байна. Бид даатгалын бус үйл ажиллагаа буюу хөрөнгө оруулалтдаа их анхаарал хандуулж байгаа. Манай нийт хөрөнгө оруулалтын 33 орчим тэрбум төгрөг байдаг. Үүний 70 хувь нь тогтмол өгөөжтэй байдаг бол үлдсэн нь алтернатив хөрөнгө оруулалт эзэлж байна. Хөрөнгө оруулалтын олз ойролцоогоор 3.3 тэрбум. Ингээд бид төлөвлөсөн бүх үзүүлэлтүүдээ амжилттай хүргэж 2.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Даатгалын компанийн амжилттай ажиллаж байгаа үгүйг дүгнэдэг гол үзүүлэлтүүд нь харьцаа үзүүлэлтүүд байдаг. Зардлын харьцаа 49.4 хувьтай, хохирлын харьцаа 48.5 хувьтай байгаа бөгөөд энэ хоёрын нийлбэр хосолсон харьцаа нь 100-с доош бага байвал сайн бөгөөд манайх өнгөрсөн онд 97.9 хувьтай ажиллажээ. Нийт хөрөнгийн өгөөж маань 4.7 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж маань 12.3 хувьтай байна. Хувьцаа эзэмшигчдийн тархалтыг авч үзвэл Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний хамаарал бүхий компаниуд хамгийн том хувьцаа эзэмшигч буюу 56.6 хувьтай, мөн үүсгэн байгуулагч Энержи Интернэйшнл Капитал ХХК 3.3 хувьтай, манай бусад жижиг хувьцаа эзэмшигчид 20 хувьтай байна. Зах зээлийн үнэлгээ бол компанийн хувьд 20 орчим тэрбум төгрөг байна. Бид зах зээлийн үнэлгээгээ нэмэгдүүлэх ирэх жилүүдэд шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх зүй ёсны шаардлага бий болж байна. Би цаашид авах арга хэмжээний талаар дэлгэрэнгүй ярья. Ирэх жилүүдэд зардлыг бууруулах цахим шилжилтийг үйл ажиллагааг эрчимтэй хийнэ. Өнгөрсөн онд олгогдсон нөхөн олговор 19

тэрбум байснаас 13 тэрбум нь зөвхөн тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагатай холбоотой, 2.1 орчим тэрбум төгрөг нь эрүүл мэнд, гэнэтийн ослын нөхөн төлбөр байгаа. Иймд бид нар нөхөн төлбөрийн зардлаа бууруулах, нөгөө талаараа үйл ажиллагааны зардалдаа анхаарах ийм 2 алхмыг зайлшгүй хэрэгжүүлэх ёстой. Үйл ажиллагааг сайжруулах хүрээндээ ISO стандартыг нэвтрүүлэх зөвшөөрөл аваад хэрэгжүүлээд эхэлсэн байгаа. Үүний хүрээнд дотоод процесс, үйл ажиллагаагаа улам чамбайруулж, нэг алхам ч гэсэн сайжруулах зорилготой байгаа. Бид 2 үндсэн стандарт буюу чанарын удирдлагын менежментийн тогтолцоо буюу 9001, нөгөө дэх нь мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо буюу 27001 хэрэгжүүлснээр бидний дотоод процесс, үйл ажиллагаа эрс сайжирна гэж үзэж байгаа. Даатгагчийн баталгаа бол тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа, чанарын баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгаа гээд маш олон төрлийн баталгаанууд байдаг. Энийг өмнө нь зөвхөн банкны салбар хэрэгжүүлдэг байсан бол өнгөрсөн жилээс даатгалын салбар хэрэгжүүлж байгаа. Энд бол ЖДҮ эрхлэгчид, ялангуяа монгол улсад баялаг бүтээгч барилга, зам, үйлчилгээ, худалдааны компаниуд маш их сонирхож байна. Энэ хүрээнд компанидаа процессоо сайжруулж, тусдаа алба байгуулах шаардлагатай болж байгаа. Мэдээж хөрөнгийн удирдлагын багцын өгөөжийг нэмэгдүүлэх ажил тогтмол хийгдээд явдаг. Мөн урамшууллын системийг дотоод, гадагшаа гэсэн 2 чиглэлд урамшууллын системийг хэрэгжүүлнэ. Нэг нь даатгалын борлуулалт хийж байгаа ажиллагсад, хүний нөөцдөө анхаарна. Мөн хууль эрх зүйн орчноо сайжруулах, хуулийн багаа хүчтэй болгох мөн хүний нөөцөө тогтоон барих буюу сайн ажилтнаа хөхүүлэн дэмжих, нөгөө талаасаа манай даатгалыг худалдаж авч байгаа нөхөн төлбөр бага гаргадаг даатгагч нараа урамшуулах системийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний хувьд зах зээл дээр маш олон шинэ бүтээгдэхүүнүүд ар араасаа бий болж байгаа. Кибер иншуранс буюу мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой даатгал, мөн нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлттэй холбоотой гэнэтийн осол, үйлдвэрийн осолтой холбоотой даатгалыг заавал даатгал болговол манай борлуулалт нэмэгдэх боломжтой. Яагаад гэвэл урт хугацааны даатгалаас салгаж хэрэгжүүлбэл жирийн ажилтан хүн өөрийн амьжиргаанд баталгаа болгох, эмчилгээний зардлаа гаргах зэргээр бид энэ даатгал дээр чухал ач холбогдол өгч ажиллана. IR хэрэгжүүлэх, сайжруулах гэдэг дээр өнгөрсөн жилүүдэд жоохон сул байсан учир одоо жижиг хувьцаа эзэмшигч нартайгаа тулж ажиллах буюу мэдээллийн солилцооны үйл ажиллагааг дэлгэрүүлэх төлөвлөгөөтэй байна. Энэ жилийн хувьд Нексия Глобал Монголиа Аудит ХХК-тай хамтран ажиллаж санхүүгийн тайлангууддаа аудит хийлгэж байгаа бөгөөд аудитын дүгнэлтийг танилцуулж өгнө үү хэмээн Нексия Глобал Монголиа Аудит ХХК-н аудитын менежер Э.Батсайхан таныг урьж байна.

Нексия Глобал Монголиа Аудит ХХК-н аудитын менежер Э.Батсайхан: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Нексия Глобал Монголиа Аудитын аудит хариуцсан ахлах менежер Э.Батсайхан. Бид Ард Даатгал ХК-ийн 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд СТОУС-ын дагуу аудит хийхээр үүрэг хүлээн гэрээ байгуулсан. Манай компани нь Лондонд төвтэй, дэлхийн 126 оронд үйл ажиллагаа явуулдаг компани

байгаа. Бид завсар үеийн аудитын 2024 оны 11 сарын сүүлээр эхэлж, жилийн эцсийн аудитыг 2 сарын сүүлээр дуусгасан. Манай аудитын багийн бүрэлдэхүүнд гүйцэтгэх захирал Э.Булган, партнер У.Нарандэлгэр, татварын партнер М.Энхмэнд, аудит менежер Э.Батсайхан, ахлах аудитор Д. Номин-Эрдэнэ, Б.Нямсүрэн гэсэн багийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаа. Нексиа Глобал Монголиа Аудит ХХК нь АССА болон Мэргэшсэн нягтлан бодогчдоор багаас бүрдүүлж, 2019 онд үүсгэн байгуулсан. Бид дараах чиглэлээр үйлчилгээ үзүүлж ажиллаж байна. Аудит, баталгаажуулалт, Татварын үйлчилгээ, Зөвлөх үйлчилгээ, Санхүүгийн үйлчилгээ, аутсорсинг, зөвлөгөө болон бусад үйлчилгээг үзүүлж ажилладаг. Ард Даатгал ХК хувьд анх удаа хамтран ажиллаж байгаа. Бид хэдийн гол асуудал бол мэдээж IFRS17 буюу даатгалын гэрээтэй холбоотой даатгалын хэрэгжилтийг мөрдүүлэх үйл ажиллагааг эхэлсэн. СТОУС 17 нь 2005 оноос хэрэгжиж эхэлсэн даатгалын гэрээний үр дүнг мөрдөх, хэрэгжүүлэх, тайлагнах олон улсын стандарт нь 2017 оны 5 сард шинэчлэгдсэн. СТОУС 17 нь 2023 оны 1 сарын 1 болон түүнээс хойш тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр болсон ба харьцуулах мэдээллийн хамт толилуулах шаардлагыг агуулсан. Компани 2024 оны 1 сарын 1-нээс эхлэх тайлант жилд СТОУС 17-г нягтлан бодох бүртгэлдээ нэвтрүүлж холбогдох бусад нягтлан бодох бүртгэлийн гол бодлогодоо өөрчлөлт оруулж санхүүгийн тайлангаа СТОУС 17-д нийцүүлэх хүрээнд харьцуулах мэдээ буюу 2023 оны дүнгүүдийг дахин тайлагнасан болно. Бид хэдийн аудитын дүгнэлт бол өмнөх онуудаас өөрчлөлтгүй “Ард Даатгал” ХК нь 2024 оны санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын (СТОУС) дагуу бэлтгэн, үнэн зөв, материаллаг алдаагүйгээр толилуулсан талаар эерэг дүгнэлт гаргасан байгаа. Тайлангийн бүтцэд СТОУС 17 холбоотойгоор нэлээн өөрчлөлт орсон байгаа жишээ нь орлого, үр дүнгийн тайлан дээр эхний хэсэгт даатгалын компанийн үйл ажиллагааг илүү ойлгомжтой, зөв илэрхийлэхийн тулд даатгалын орлого, даатгалын үйлчилгээний үр дүн, хоёрдугаар хэсэгт хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа буюу туслах үйл ажиллагааны үр дүн, гуравдугаар хэсэгт ерөнхий удирдлага болон борлуулалт маркетингийн үр дүнгүүдийг тусгасан байгаа. Эндээс харвал даатгалын үйл ажиллагаанаас 8.8 тэрбум, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас 3.2 тэрбум гээд цэвэр ашиг нь 2.4 тэрбум байна. Дараагийн хэлэлцэх асуудал маань ногдол ашиг олгосон тайланг танилцуулах байгаа.

Ард Даатгал ХК-н ЭУХГ-н захирал Г.Баярбат: Өнгөрсөн онд 750 сая төгрөгийн ногдол ашиг олгосон. 2024 оны 2-р сарын 8-ны ТУЗ-н тогтоолоор нэгж хувьцаанд 30 төгрөг буюу нийтдээ 750 сая төгрөгийн ногдол ашгийг 2024 оны 4 сарын 25-ны өдөр ҮЦТХТ-тэй хамтран хувьцаа эзэмшигчдийнхээ дансанд байршуулсан байгаа. Харин энэ оны хувьд 2025 оны 2 сарын 11-ний хурлаар ногдол ашиг олгохгүй байх шийдвэр гаргасан. Яагаад гэвэл дараах 3 шалтгаантай. Нэгт эздийн өмч болон хувьцааны үнэ цэнээ нэмэгдүүлэх, хоёрдугаарт төлбөрийн чадвараа нэмэгдүүлэх, илүү сайжруулах, гуравдугаар компанийн хувьд түрээсийн бус өөрсдийн оффистой болох зорилттой уялдуулж ийм шийдвэр гарсан. Хурлын дэгийн дагуу дараагийн хэлэлцэх асуудал маань ТУЗ-н үйл ажиллагааны тайланг танилцуулах байгаа. Танилцуулж өгнө үү хэмээн ТУЗ-н хараат бус гишүүн, хурлын дарга Болорчимэг таныг урьж байна.

Олгосон хэлбэр	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Хувьцааны тоо	Ногдол ашиг	Татварын дараах ногдол ашиг	Хувь
ҮЦТХТ	9,725	11,445,336	343,360,080	324,830,331	46%
Хуулийн этгээд	19	2,717,104	81,513,120	77,437,464	11%
Дотоодын иргэн	9,683	8,425,622	252,768,660	240,130,227	34%
Гадаадын иргэн	23	302,610	9,078,300	7,262,640	1%
Компаниас шууд олгосон	7	13,554,664	406,639,920	386,307,924	54%
Хуулийн этгээд	7	13,554,664	406,639,920	386,307,924	54%
Дотоодын иргэн	-	-	-	-	0%
Гадаадын иргэн	-	-	-	-	0%
НИЙТ ДҮН	9,732	25,000,000	750,000,000	711,138,255	100%

ХЭХ-н дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Болорчимэг: За Ард Даатгал ХК-н ТУЗ-н үйл ажиллагааны тайланг танилцуулъя. Төлөөлөн Удирдах Зөвлөл маань 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулдгийг та бүхэн мэдэж байгаа, нэлээн тогтвортой ажиллаж байгаа гишүүд. ТУЗ-н даргаар О.Одбаяр, ердийн гишүүдээр Г.Уянга, Б.Золбоо, Г.Цогбадрах, С.Оргил, Ч.Ганзориг нар ажилладаг. Харин хараат бус гишүүдээр З.Ариун, Т.Билгээ, миний бие Б.Болорчимэг нар ажилладаг байгаа. Төлөөлөн Удирдах Зөвлөл маань өнгөрсөн жил 7 ээлжит бус хурал, 2 эчнээ хурал гээд нийт 9 хурлаар 24 асуудлыг шийдвэрлэсэн байна. Голлох шийдвэрүүдээс дурдвал ногдол ашиг хуваарилах тухай, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай, 2023 оны аудитлагдсан тайланг дүгнэж ТУЗ-ийн дүгнэлт гарган батлах тухай, гүйцэтгэх захирлын үнэлгээ батлах тухай, шинэ бүтээгдэхүүн батлах тухай, гүйцэтгэх захирал чөлөөлөх тухай, гүйцэтгэх захирал томилох тухай, компанийн 2025 оны төсөв төлөвлөгөө батлах зэрэг шийдвэрүүдийг гаргажээ. ТУЗ-н дэргэдэх хороод буюу Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны хувьд Б. Болорчимэг, Г. Цогбадрах, З. Ариун бүрэлдэхүүнтэйгээр нийт 3 ээлжит хурлаар дараах 12 асуудлыг хэлэлцсэн байна. Харин Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо нь Б.Золбоо, С.Оргил, Т.Билгээ, Г.Уянга, З.Ариун гэсэн бүрэлдэхүүнтэйгээр нийт 4 удаагийн ээлжит хурлаар 24 асуудлыг хэлэлцжээ. Мөн аудитын хороо буюу З.Ариун, Т.Билгээ, Г.Уянга нар маань мөн 4 ээлжит хурлаар 16 асуудлыг хэлэлцсэн байна.

Үргэлжлүүлээд ТУЗ-н төсвийг танилцуулж өгнө үү хэмээн Ард Даатгал ХК-н ЭУХГ-н захирал Г.Баярбат-г урьж байна.

Ард Даатгал ХК-н ЭУХГ-н захирал Г.Баярбат: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийн хувьд ТУЗ-н гишүүдийн маань цалин, хурал зохион байгуулах зардал болон урамшуулал гэсэн 3 бүрэлдэхүүнтэй байдаг. Урамшууллын хувьд гишүүддээ олон улсын эрүүл мэндийн даатгалд үнэлгээ дээр нь үндэслээд хамруулдаг байгаа. Дэлгэрэнгүйг энэхүү слайдаас харж болно.

ТУЗ-н зардал	Дүн		YOY
	2024	2025	
Цалин	140	181	29.9%
Хурал зохион байгуулах	10	25	2.5x
Урамшуулал	45	62	36.9%
НИЙТ ЗАРДАЛ	195	268	37.7%

Дараагийн асуудал маань 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н дүгнэлтийг батлах асуудал байгаа. Үүн дээр хувьцаа эзэмшигчид маань саналаа өгөөд шийдвэр гаргах ёстой асуудал байгаа. Түрүүн үзүүлсэн аудитлагдсан тайлан дээр ТУЗ маань хангалттай гэж дүгнэсэн байгаа. Үүний дараагаар ТУЗ-н гишүүдийг сонгох байгаа. Та бүхэндээ шинээр дэвшиж буй нэр дэвшигчдийг танилцуулъя. Эхлээд дахин нэр дэвшиж буй хүмүүсээ дурдвал ТУЗ-н дарга О.Одбаяр, ердийн гишүүн буюу Ард Пропертиз ХХК-н гүйцэтгэх захирал Г.Уянга, Ард Экс ХХК-н гүйцэтгэх захирал Ч.Ганзориг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-н гүйцэтгэх захирал Б.Золбоо, Мост Финтек ХК-н захирал С.Оргил, ердийн гишүүн Г.Цогбадрах нар ердийн гишүүн дээр дахин нэр дэвшиж байна. Хараат бус гишүүнд Өрөг.мн үүсгэн байгуулагч Б.Болорчимэг, Эрдэнэс Баянбогд ХХК-н Уул уурхайн газрын захирал Т.Билгээ нар дахин нэр дэвшээд байна. Одоо шинээр нэр дэвшиж буй хүмүүсийг танилцуулбал ердийн гишүүн дээр Ард Даатгал ХК-н гүйцэтгэх захирал Н.Эрдэнэтулга, хараат бус гишүүн дээр МЭХЗХ-н Хяналт, үнэлгээ хариуцсан захирал Б.Мэндбаяр, Монгол ТВ ХХК-н хөтлөгч Т.Хонгорзул болон Монгол Шуудан ХК-н дэд захирал Н.Хосбаяр нар тус тус шинээр нэр дэвшиж байна. Та бүхэн саналаа өгөхдөө ердийн гишүүнээс 6, хараат бус гишүүнээс 3 сонгох байгаа эсвэл нийт хувьцааныхаа тоог 9-т үржүүлээд нэг хүнд өгч болно. Асуулт, хариулт хэсэгт асуултууд маань явах бөгөөд тухайн хэсэг дээр нийт асуултад хариулъя. Дараагийн асуудал буюу энэ хурлын хамгийн сүүлийн асуудал нь компанийн дүрэмд өөрчлөлт оруулах байгаа.

1. Ард Даатгал ХК-ийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулсугай.

1.1. Ард Даатгал ХК-ийн дүрмийн 1.4-д “Компанийн бэлгэдэл тэмдэг нь ARD гэсэн гурван үсгээс бүрдсэн улаан өнгөтэй байх ба хажууд нь Даатгал since 1994 гэж бичсэн байна” гэж заасныг “Компани “Хүчтэй.Хамтдаа.” гэсэн уриа үгтэй байх бөгөөд Компанийн бэлгэдэл тэмдэг нь ARD гэсэн гурван

үсгээс бүрдсэн улаан өнгөтэй байх ба хажууд нь Даатгал since 1994 гэж бичсэн байна” гэж өөрчлөх;

2. Ард Даатгал ХК-ийн дүрэмд дараах нэмэлтийг оруулсугай.

2.1. Компанийн дүрмийн 1.6 дахь хэсэгт “Компани нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, үйлчлүүлэгч, ажиллагсададаа урамшуулах зорилгоор өөрсдийн урамшууллын оноо АрдКойн ашиглана. Энэ нь бусад хэлбэрээр урамшуулал олгохыг хориглох заалт болохгүй” гэж;

2.2. Компанийн дүрмийн 1.7 дахь хэсэгт “Компани нь Хөрөнгө Оруулагч Үндэстэн цогцлоох эрхэм зорилготой ажиллана” гэж тус тус нэмэх

Үүн дээр бас та бүхэн саналаа өгч шийдвэр гаргана. Мөн нийт нэр дэвшигчдэдээ бүгдэд нь амжилт хүсье. Хувьцаа эзэмшигчид маань санал өгөх заавартай сайн танилцаарай.

Ард даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Н.Эрдэнэтулга: Хэлэлцсэн асуудлуудтай холбогдуулан асуух асуулт болон хэлэх санал байна уу? За онлайнаар ирсэн асуултууд ирсэн байна үүнд хариулъя.

Онлайнаар ирсэн асуулт: Даатгал хийлгэж байгаа хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нартаа урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх ямар арга хэмжээ авч байгаа вэ?

Хариулт Н.Эрдэнэтулга: Компанийн зүгээс хувьцаа эзэмшигчдэдээ чиглэсэн урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Тухайлбал, Ард Даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчид нь компанийн бүтээгдэхүүн үйлчилгээг авахдаа **20 хувийн хөнгөлөлт** эдлэх боломжтой. Энэ нь компанийн үнэнч хэрэглэгч, хөрөнгө оруулагчдыг дэмжих, хамтын оролцоог нэмэгдүүлэх зорилготой тогтмол хэрэгжүүлдэг бодлого юм. Цаашид ч энэ төрлийн урамшууллын хүрээг өргөжүүлэх талаар судалгаа хийж, хөрөнгө оруулагчидтай илүү ойр байхаар зорьж байна.

Онлайнаар ирсэн асуулт: Ардын бүх компаниуд ногдол ашиг хуваарилахгүй юм уу?

Хариулт Н.Эрдэнэтулга: Ард Санхүүгийн Нэгдлийн бүрэлдэхүүнд багтдаг компани бүр өөрийн бизнесийн онцлог, санхүүгийн үзүүлэлт, ТУЗ-ийн шийдвэрийн дагуу ногдол ашиг хуваарилах эсэхээ тус тусдаа шийдвэрлэдэг. Манай компанийн хувьд энэ удаад ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн болно.

Та бүхэнд өөр санал асуулт асуулт байна уу? За асуулт байхгүй бол санал хураалт үүгээр эхэлж байна. Та бүхэн саналаа идэвхтэй өгөөрэй баярлалаа.

ТУЗ-ийн дарга О.Одбаяр: За санал хураалт дууссан байна. Одоо тооллогын комиссын дарга Бямбагэрэл санал хураалтын дүнг танилцуулна.

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл: Та бүхэнд тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя.

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №02

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дахь хэсгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай санал хураалтад 17,244,983 ширхэг буюу 69 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

- 1.1. Зөвшөөрсөн 16,768,376 ширхэг буюу 97.2%;

- 1.2.Татгалзсан 200 ширхэг буюу 0.002%;

- 1.3.Түдгэлзсэн 0 ширхэг буюу 0.00% байх тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №3

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалтын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг сонгох тухай санал хураалтад 17,244,983 ширхэг энгийн хувьцаа буюу 69 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Саналын тоо	Хувь
---	--	-------------	------

Ердийн гишүүд

1	О.Одбаяр	16,590,636	96.2%
2	Г.Уянга	16,601,489	96%
3	Ч.Ганзориг	1,361,043	8%
4	Б.Золбоо	16,635,869	96.4%
5	С.Оргил	16,429,929	95.2%
6	Г.Цогбадрах	17,244,983	100%
7	Н.Эрдэнэтулга	15,542,422	90.1%

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Саналын тоо	Хувь
---	--	-------------	------

Хараат бус гишүүд

1	Б.Болорчимэг	16,584,071	96.1%
2	Т.Билгээ	156,937	1%
3	Б.Мэндбаяр	10,591	0.06%
4	Г.Хонгорзул	16,431,049	95.2%
5	Н.Хосбаяр	16,564,277	96.05%

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №4

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хурлаар хэлэлцсэн Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 17,244,983 ширхэг буюу 69 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос 17,104,183 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгсөн ба үүнээс:
 - 1.1. Зөвшөөрсөн 17,104,078 ширхэг буюу 99.1%;
 - 1.2. Татгалзсан 105 ширхэг буюу 0.001%;
 - 1.3. Түдгэлзсэн 0 ширхэг буюу 0.00% байх тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Тооллогын комиссын тогтоолыг танилцуулж дууслаа. Баярлалаа.

ХЭХ-н дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Болорчимэг: Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл танд баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалт амжилттай явж дүнгээ танилцууллаа. За одоо хурлаас гарсан шийдвэрийг та бүхэнд танилцуулъя.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ №01/25

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 2025 оны 4 сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №2 тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсралтаар баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ №02/25

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 2025 оны 4 сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №3 тоот тогтоолуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр О.Одбаяр, Г.Уянга, Б.Золбоо, Г.Цогбадрах, С.Оргил, Н.Эрдэнэтулга нарыг, хараат бус гишүүнээр Б.Болорчимэг, Т.Хонгорзул, Н.Хосбаяр нарыг тус тус сонгохыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн мэдээллийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж, зохих зөвшөөрлийг авч ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Г.Баярбат)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ №03/25

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дахь хэсэг, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6.1 дэх хэсэг болон 2025 оны 4 сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №4 тоот тогтоолуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулсугай.

1.1 Ард Даатгал ХК-ийн дүрмийн 1.4-д “Компанийн бэлгэдэл тэмдэг нь ARD гэсэн гурван үсгээс бүрдсэн улаан өнгөтэй байх ба хажууд нь Даатгал since 1994 гэж бичсэн байна” гэж заасныг “Компани “Хүчтэй.Хамтдаа.” гэсэн уриа үгтэй байх бөгөөд Компанийн бэлгэдэл тэмдэг нь ARD гэсэн гурван үсгээс бүрдсэн улаан өнгөтэй байх ба хажууд нь Даатгал since 1994 гэж бичсэн байна” гэж өөрчлөх;

2. Ард Даатгал ХК-ийн дүрэмд дараах нэмэлтийг оруулсугай.

2.1. Компанийн дүрмийн 1.6 дахь хэсэгт “Компани нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, үйлчлүүлэгч, ажиллагсаддаа урамшуулах зорилгоор өөрсдийн урамшуулын оноо АрдКойныг ашиглана. Энэ нь бусад хэлбэрээр урамшуулал олгохыг хориглох заалт болохгүй” гэж;

2.2. Компанийн дүрмийн 1.7 дахь хэсэгт “Компани нь Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох эрхэм зорилготой ажиллана” гэж тус тус нэмэх;

3. Энэхүү шийдвэрийн 1, 2 дахь хэсэгт заасан нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж хавсралтаар баталсан Компанийн дүрмийг хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Н.Эрдэнэтулга)-д даалгасугай.

Ийнхүү хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр тогтоолыг баталсныг мэдэгдье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг баталснаар амжилттай өндөрлөлөө. Хурлаа амжилттай зохион байгуулсан Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн гишүүд, удирдлагын багт талархлаа илэрхийлье. Хувьцаа эзэмшигчиддээ баярлалаа. Хурлыг хаасныг албан ёсоор мэдэгдэж байна.

ХУРЛЫН ДАРГА



Б.БОЛОРЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.БАЯРБАТ